



ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2016 оны 09 сарын 15 өдөр

Дугаар 3/27

Улаанбаатар хот

Ажилд томилох тухай

Монгол Улсын Статистикийн тухай хуулийн 15¹ дүгээр зүйлийн 15^{1.1} дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.4, 27 дугаар зүйлийн 27.2.3, Засгийн газрын 2014 оны 332 дугаар тогтоол, Үндэсний статистикийн хорооны даргын 2016 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн А/17 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Статистикийн тухай хуулийн 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн нэмэлт өөрчлөлт болон Монгол Улсын Их Хурлын 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэх тухай” 12 дугаар тогтоолын дагуу Үндэсний статистикийн хороо шинэчлэн байгуулагдсан тул 2016 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс Архангай аймгийн статистикийн хэлтсийн албан хаагчдыг нэгдүгээр, Баян-Өлгий аймгийн статистикийн хэлтсийн албан хаагчдыг хоёрдугаар, Баянхонгор аймгийн статистикийн хэлтсийн албан хаагчдыг гуравдугаар, Булган аймгийн статистикийн хэлтсийн албан хаагчдыг дөрөвдүгээр, Говь-Алтай аймгийн статистикийн хэлтсийн албан хаагчдыг тавдугаар, Дорноговь аймгийн статистикийн хэлтсийн албан хаагчдыг зургаадугаар, Дорнод аймгийн статистикийн хэлтсийн албан хаагчдыг долоодугаар, Дундговь аймгийн статистикийн хэлтсийн албан хаагчдыг наймдугаар, Завхан аймгийн статистикийн хэлтсийн албан хаагчдыг есдүгээр, Өвөрхангай аймгийн статистикийн хэлтсийн албан хаагчдыг аравдугаар, Өмнөговь аймгийн статистикийн хэлтсийн албан хаагчдыг арван нэгдүгээр, Сүхбаатар аймгийн статистикийн хэлтсийн албан хаагчдыг арван хоёрдугаар, Сэлэнгэ аймгийн статистикийн хэлтсийн албан хаагчдыг арван гуравдугаар, Төв аймгийн статистикийн хэлтсийн албан хаагчдыг арван дөрөвдүгээр, Увс аймгийн статистикийн хэлтсийн албан хаагчдыг арван тавдугаар, Ховд аймгийн статистикийн хэлтсийн албан хаагчдыг арван зургаадугаар, Хөвсгөл аймгийн статистикийн хэлтсийн албан хаагчдыг арван долоодугаар, Хэнтий аймгийн статистикийн хэлтсийн албан хаагчдыг арван наймдугаар, Дархан-Уул аймгийн статистикийн хэлтсийн албан хаагчдыг арван есдүгээр, Орхон аймгийн статистикийн хэлтсийн албан хаагчдыг хорьдугаар, Говьсүмбэр аймгийн статистикийн хэлтсийн албан хаагчдыг хорин нэгдүгээр хавсралтаар тус тус томилж, албан тушаалын ангилал зэрэглэл, цалин нэмэгдлийг тогтоосугай.

2. Албан хаагчдын албан тушаалын цалин нэмэгдлийг хавсралтад заасны дагуу томилогдсон өдрөөс эхлэн тооцож олгохыг аймгийн статистикийн хэлтсийн дарга, нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ч.ЦЭВЭГДОРЖ